

“ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Төсөл

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, хэрэгцээ

Дэлхий дахинд залуучуудыг улс орны хөгжлийг тодорхойлогч, эх орны ирээдүйн эзэд хэмээн хүлээн зөвшөөрч, тэдний өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд тэдний оролцоог хангах, дэмжих, хөгжих боломж олгоход анхаарал хандуулах нь нэн чухал болоод байна.

Манай улсын хувьд НҮБ-тай хамтран 2013-2017 онуудад 13 аймагт “Залуучуудын хөгжлийн төв”-ийг бий болгон, үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсанаар ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтцэд залуучуудын асуудлыг хариуцуулан ажиллаж эхлээд байна. Монгол улсад анх удаа Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 2017 оны 05 дугаар сарын 18-нд баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлээд байна.

Монгол улсын нийт хүн амын 34.6% нь 15-34 насны залуучууд байдаг бөгөөд бусад бүлгийн хүн амтай харьцуулахад дийлэнх хувийг эзэлж байгаа юм.

- 2016 оны эцсийн байдлаар Дундговь аймаг нийт 45515 хүн амтайгаас 15-34 насны залуучууд 15379 буюу нийт хүн амын 33,8%-ийг эзэлж байна. Аймгийн хэмжээний 15-34 насны залуучуудынажиллах хүч-15379 бөгөөд үүнээс:
 - Ажилтай 6700
 - Ажилгүй 8679 залуучууд тус тус эзэлж байна.
- Аймгийн хэмжээнд 2016 оны байдлаар нийт 305 иргэн гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Үүнээс гэрлэлтээ бүртгүүлсэн иргэдийн 89.3 %-ийг 15-34 насны залуучууд эзэлж байна.
- Аймгийн хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн 51%-ийг 15-34 насны залуучууд эзэлж байгаагаас харахад дээд боловсрол эзэмших нь чухал, өөрөөр ажил орлоготой байх арга зам байхгүй мэтээр ойлгодог хандлага залуучуудын дунд газар авч, чанартай, чанаргүй их, дээд сургуульд суралцаж гэрчилгээ, дипломтой болохыг эрхэмлэх болсон төдийгүй мэргэжлийн сургалтын төвүүдэд суралцаж, мэргэжил эзэмших залуусын тоо цөөрсөнтэй холбоотой байна. Иймээс өсвөр насны сурагчдыг мэргэжил сонголтын талаар үнэн зөв, бодитой мэдээллээр хангах нь чухал байгаа юм.

Аймгийн хэмжээний 15-34 насны залуучуудыг боловсролын түвшингээр нь авч үзвэл:



Аймгийн хэмжээнд нийт 12171 малчин байгаагаас 15-34 насны залуучууд 3948 буюу нийт малчдын 32.4%-ийг эзэлж байгаа бөгөөд малчин залуучуудын эдийн засаг, нийгэм-соёлын амьдралд оролцох, оролцоог нэмэгдүүлж, тэдний хөгжих боломжоор хангаж ажиллах нь нэн тэргүүний чухал зорилтуудын нэг болоод байна.

- Аймгийн хэмжээнд 15-34 насны залуучуудын шилжилт хөдөлгөөн ихсэж байгаа бөгөөд өөр аймаг, хотруу шилжин явсан

- Эрэгтэй-304
- Эмэгтэй-355 буюу нийт шилжин явсан 659 иргэний 57.1%-

ийг 15-34 насны залуучууд эзэлж байна.

Иймээс ирээдүйн түүчээ болсон залуучуудаа хөгжүүлэх, тэднийг нийгмийн амьдралд идэвхитэй оролцуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн Дундговь аймгийн “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг боловсруулж байна.

Энэхүү хөтөлбөр нь орон нутгийн залуучуудад тулгамдаж буй асуудал бэрхшээлийг тодорхойлж, залуучуудын нийгмийн амьдралд оролцох оролцоо, хөгжлийн хэрэгцээг хангах зорилгоор Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, /Дундговь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.5.3/-ийг хэрэгжүүлэхтэй нягт уялдаа холбоотой юм.

Хоёр. Хөтөлбөрийн зарчим

2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална.

2.2.Хөтөлбөрийн зорилго, зорилт тодорхой, зорилтот үйл ажиллагаа нь залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн байх

2.3 Залуучуудын эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх

2.4Залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах

2.5Залуучуудын эрхийг дээдэлсэн, тэгш хүртээмжтэй байх

2.6 Салбар хоорондын хамтын ажиллагааг хангах, нэгдмэл цогц байх

2.7 Залуучуудад чиглэгдсэн үйл ажиллагаанууд ил тод, нээлттэй байх

Гурав. Хөтөлбөрийн зорилго

3.1 Хөтөлбөрийн зорилго нь залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлж, өсвөр үе, залуучуудыг амьдрах ухааны чадварт сургах, орон нутгийн нийгэм соёл, эдийн засгийн хөгжилд оролцох залуучуудын оролцоог нэмэгдүүлэн, үзэл бодлоо оновчтой илэрхийлэх чадвартай, харилцааны соёлтой залуу үеийг төлөвшүүлэхэд оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

4.1Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.1 Нийгэм, эдийн засгийн амьдралд залуучуудын оролцох оролцоог нэмэгдүүлэх

4.1.2 Залуучуудад амьдрах ухааны боловсрол олгож, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

4.1.3 Залуучуудын эрүүл мэндийг дэмжиж, эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх,эрүүл зан үйлийг төлөвшүүлэх

4.1.4Залуучуудын авьяас чадварыг дэмжин, соёл урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах, түүх, соёл, уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд залуусын оролцоог нэмэгдүүлэх

4.1.5 Өсвөр үе, залуучуудын боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1 Нийгэм, эдийн засгийн амьдралд залуучуудын оролцох оролцоог сайжруулах зорилтын хүрээнд:

5.1.1 “Залуусын оролцоо- Хөгжлийн гарц” залуучуудын чуулга уулзалтыг 2 жил тутамд зохион байгуулж, шийдвэр гаргах түвшинд залуучуудын санал бодлыг хүргэж, орон нутгийн бодлого шийдвэрт залуучуудын оролцоог хангах

5.1.2 Залуучуудын сонирхолд түшиглэн сайн дурын бүлгэм, сонирхлын бүлэг, клуб байгуулах, тэдний санал санаачилгыг дэмжиж, залуучуудад зориулсан сургалт, сурталчилгаа, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

5.1.3 Залуучуудын хүмүүнлэгийн болон сайн дурын ажилд оролцох оролцоог дэмжиж, нийгмийн сайн сайхны төлөө үлгэр дууриалал болохуйцаар ажиллаж, амьдарч буй залуусын сайн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан алдаршуулж, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх

5.1.4 Урлаг, спорт, ажлын амжилтаараа манлайлагч залуучуудыг урамшуулан, олон улсын хэмжээнд мэдлэг, ур чадвар, авхаалж самбаагаа сориход нь дэмжлэг үзүүлэх ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэн зохион байгуулах

5.1.5 Аймгийн “Шилдэг залуу” шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, тэднийг алдаршуулан, бусад залуучуудад туршлага солилцох, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах

5.1.6 Аймгийн Засаг даргын нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг бий болгох

5.1.7 Тодорхой салбарын залуучуудын зөвлөгөөн зохион байгуулах /Төрийн албан хаагч залуучууд, залуу багш нар, залуу малчид, залуу эмч нар, малчин залуу, төрийн тусгай байгууллагуудын залуучууд гэх мэт/

5.1.8 Орон нутгийн удирдлагууд /Аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга гэх мэт/-тай залуучуудын төлөөлөл уулзалт зохион байгуулж, үзэл бодлоо илэрхийлэх, дуу хоолойгоо хүргэх “Хөгжлийн түүчээ” залуучуудаа сонсох өдөртэй болох

**5.2 Залуучуудад амьдрах ухааны боловсрол олгож, хөдөлмөр
эрхлэлтийг зорилтын хүрээнд:**

5.2.1 Ажил хөдөлмөр эрхлэх сонирхолтой, хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй залуучуудыг амьдрах ухааны чадвар олгох болон мэргэжил олгох сургалтуудад хамруулж, ажилд зуучлах

5.2.2 Хувийн бизнес эрхэлж байгаа болон бизнесээ эхлүүлж байгаа залуучуудыг бизнесээ өргөжүүлэх болон шинээр бизнес эрхлэхэд нь мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх, төсөл хөтөлбөрүүдэд холбон зуучлах

5.2.3 Гарааны бизнес эрхлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн залуучуудын шинэлэг санал, оюуны бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрт санхүүгийн болон удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх

5.2.4 Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын нийгмийн амьдралд оролцох идэвх оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэх санал санаачлагыг дэмжин, мэдээллээр хангах

5.2.5 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгссөн, ажил хөдөлмөр эрхлэх чин хүсэлтэй, мэргэжлийн ур чадвартай, чадварлаг боловсон хүчнийг ажлын байраар хангасан аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, урамшуулах

**5.3 Залуучуудын эрүүл мэндийг дэмжиж, эрүүл аюулгүй амьдрах орчныг
бүрдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд:**

5.3.1 Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвийг байгуулж, төвөөр өсвөр үе, залуучуудад чиглэсэн амьдрах ухааны боловсрол олгох, эрүүл мэндийн сургалт, зөвлөгөө, мэдээ мэдээллээр тогтмол хангах

5.3.2 Өсвөр үе, залуучуудад архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг ойлгуулах, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар зөв хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах

5.3.3 Эрсдэлт бүлгийн залуучуудыг БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, мэдээлэл зөвлөгөө болон сайн дурын зөвлөгөө шинжилгээнд хамруулж хэвшүүлэх

5.3.4 Залуучуудыг үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулдаг тогтсон өдөртэй болгох

5.3.5 Аймаг орон нутагтаа хийгдсэн бүтээн байгуулалтыг хайрлаж хамгаалахад олон нийтийг уриалах зорилгоор залуучуудын дунд “Бид Дундговийн залуус” аяныг өрнүүлэх

5.3.6 Залуучууд болон залуу гэр бүлүүд чөлөөт цагаа өнгөрүүлэх, амрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Хайрын төгөл” /гудамж/ бий болгох

5.4 Залуучуудын авьяас чадварыг дэмжин, соёл урлаг, спортын арга хэмжээнд оролцох, түүх, соёл, уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд оролцох боломжийг өргөжүүлэх зорилтын хүрээнд:

5.4.1 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж байгаа урлаг соёл, спортын үйл ажиллагаанд залуучуудыг татан оролцуулах, залуучуудаас санаачлан зохион байгуулж буй энэ төрлийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах

5.4.2 Ардын урлаг, уламжлалт тоглоом, наадгайг хөгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэхэд залуучуудын идэвх оролцоог дэмжих

5.4.3 Урлаг, спортын авьяас чадвар, ажлын амжилтаараа үеийн залуусаа манлайлан суралцаж, ажиллаж байгаа залуучуудыг шагнал урамшуулалд хамруулах

5.4.4 Ахмад болон залуу үеийн залгамж холбоог бэхжүүлж, залуучуудад ахмад үеэсээ суралцах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор залуучуудыг угийн бичиг хөтлөх сургалтад хамруулж, мэдээллээр ханган, угийн бичиг хөтлүүлж, түгээн дэлгэрүүлэхэд оролцуулах

5.4.5 Залуучуудыг амьдралд бэлтгэхэд нөлөөлөх үйл ажиллагаагаар ахмад үе эцэг эхийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах

5.4.6 Өсвөр, үе залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх, иргэний үүргээ ухамсарлуулахад чиглэгдсэн нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах

5.5 Өсвөр үе, залуучуудын боловсролын чанарт анхаарч, залуучуудын өрсөлдөх чадварыг сайжруулах зорилтын хүрээнд:

5.5.1 Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулан, залуучуудын нийгмийн идэвхийг сайжруулах

5.5.2 Ахлах ангийн сурагчдад зориулан ажил, мэргэжил болон суралцах сургуулиа зөв сонгох, их, дээд сургуульд элсэн суралцахад нь дэмжлэг үзүүлж, зөвлөгөө өгөх, их, дээд сургуулиудын өдөрлөгийг жил бүр зохион байгуулах

5.5.3 Гоц авьяастай, оюуны өндөр чадвартай залуучуудыг сургах, оюуны бүтээлийг нь дэмжих, олон нийтийн хүртээл болгож, алдаршуулах

5.5.4 Ерөнхий боловсролын болон МСҮТ, насан туршийн боловсролын төвтэй хамтран хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах

5.5.5 Тодорхой сэдвүүдийн хүрээнд өсвөрийн сургагч багш нарыг бэлтгэж, өсвөр үеийнхний бусаддаа нөлөөлөх чадварыг нэмэгдүүлж, бие биенээсээ суралцах боломжийг олгох

5.5.6 Төрийн албан хаагч залуучуудыг мэргэжлийн мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлэхэд анхаарч, бусад аймаг орон нутгийн болон сумдын албан хаагчидтай солилцооны хөтөлбөрт хамруулан, туршлага судлуулах

Зургаа. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

6.1 Хөтөлбөрийг 2018-2021 он хүртэл 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1 Улс, орон нутгийн төсөв

7.3 Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, зээл тусламж, хандив

7.4 Орон нутгийн хөгжлийн сан

7.5 Сум хөгжлийн сан

7.6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

7.7 Аймгийн Засаг даргын нөөц

7.8 Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

8.1 Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Залуучуудын төрийн болон төрийн бус байгууллага, нэгдэл, зөвлөл, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл оролцсон хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.

8.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, мэдээллээр хангах, хяналт тавих, жил бүр хэрэгжилтийн явцыг гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнах үүргийг хөтөлбөр хэрэгжүүлэх зөвлөл хариуцна.

8.3 Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргах цаашдын үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

8.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийг тухай бүр нь Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчилна.

Ес. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

9.1 Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд хүрч, төвийн үйл ажиллагааг аймгийн нийт залуучуудын 50 %-иас дээш хувь нь мэддэг болсон байна.

9.2 Залуучуудын нийгмийн идэвх оролцоо, орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр, бүтээлч хандлага дээшилсэн байна.

9.2 Залуучуудын мэдлэг боловсрол, амьдрах ухааны ур чадвар, гэр бүл төлөвлөлт, эрүүл мэндийн мэдлэг нь дээшилсэн байна.

9.4 Залуучуудын хөгжлийн төвөөр 15-34 насны залуучуудын 30% үйлчлүүлсэн байна.

9.5 Залуучууд жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагдаж хэвшсэн байна.

9.6 Залуучуудын хөгжлийг дэмжих тэднийг урамшуулах нөхцөл бүрдсэн байна.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

- 10.1 Залуучуудын хөгжлийн төвөөрүйлчлүүлсэн залуучуудын тоо
- 10.2 Сайн дурын үйл ажиллагаанд оролцсон залуучуудын тоо
- 10.3 Төр болон төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудын чанар, үр дүн
- 10.4 Залуучуудын хөгжил, оролцоонд чиглэсэн олон нийтийн арга хэмжээний тоо
- 10.5 Өсвөр үе, залуучуудад зохион байгуулсан сургалтын тоо, сургалтад оролцогчдын тоо
- 10.6 Өсвөр үе, залуучуудад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн тоо, чанар, үр дүн
- 10.7 Залуучуудын хөгжлийн төвийн амьдрах ухааны чадвар олгох сургалтад хамрагдсан залуучуудын тоо
- 10.8 Эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагдсан залуучуудын тоо

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР